



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/128


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шарилжгүй Улаанбаатар-4 аяны хүрээнд зориулалтын гербицидээр шарилж устгахтай холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба "Чансаа Хан хөхий холдинг" ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан Шарилж, зэрлэг ургамал устгах зориулалттай 10,5 тн гербицид нийлүүлэх 18/06-410 дугаар гэрээт ажлын нэмэлтээр 2.5 тн гербицид худалдан авах ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуульд зааснаар гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. Дээрх ажилд шаардагдах 10 000 000 /Арван сая/ төгрөгийг Гэр хороолол, орон сууцны хорооллын доторх зэрлэг ургамлыг устгах төсөвлөгдсөн зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

